



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/38/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор:
Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.06.13 № 39
танай _____ ны № _____ Т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ц.УУГАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан батлагдсан төсвийн дагуу 770.2 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 769.3 сая төгрөгийг зарцуулж, 1 орон тоогоор дутуу, өглөг, авлагагүй, тайлагнаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Булган аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/30 тоот "Эд хөрөнгө бүртгэх тухай", Сэлэнгэ сумын ИТХ-ын XI хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11/07 тоот "Өмч хөрөнгө шилжүүлж данс бүртгэлд бүртгүүлэх тухай" тогтоол шийдвэрийн дагуу шилжүүлэн авсан 16.2, ОНХО-аар бэлтгэгдсэн 25.1 сая төгрөгийн нийт 41.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч тайлагнасан байна.

№ 006020043

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2 зорилтын хүрээнд 217 ажил төлөвлөснөөс 209 арга хэмжээ нь бүрэн биелэгдэж, 8 ажил нь дутуу хэрэгжиж 96.2 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,866,559.00</u>	<u>77,392,406.00</u>
33	АВЛАГА	<u>2413520</u>	<u>0.00</u>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2413520	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,453,039.00	77,392,406.00
354	Хангамжийн материал	50,038,039.00	69,554,406.00
35410	Бичиг хэргийн материал	-	112,000.00
35420	Аж ахуйн материал	38,499,239.00	33,402,256.00
35470	Бусад хангамжийн материал	11,538,800.00	36,040,150.00
35600	Мал амьтад	8,415,000.00	7,838,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>779,378,464.18</u>	<u>737,147,411.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	779,378,464.18	737,147,411.76
392	Биет хөрөнгө	763,809,464.18	721,998,411.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	380,167,599.83	379,685,599.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,662,435.22)	(20,796,730.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,101,740.00	138,951,740.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,896,430.63)	(71,348,959.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,672,811.00	130,112,067.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,341,001.29)	(36,845,458.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,244,349.10	8,425,640.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,237,515.40)	(1,062,866.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	329,711,887.00	315,294,264.30

39215	Хуримтлагдсан элэгдэл	(124,951,540.21)	(120,416,883.93)
393	Биет бус хөрөнгө	15,569,000.00	15,149,000.00
39301	Програм хангамж	2,400,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(615,000.00)	(735,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,784,000.00	13,784,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	840,245,023.18	814,539,817.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	840,245,023.18	814,539,817.76
51	Засгийн газрын хувь оролцоо	837,831,503.18	814,539,817.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	458,014,431.00	458,014,431.00
51101	Өмч: - төрийн	458,014,431.00	458,014,431.00
512	Хуримтлагдсан үр дүн	(15,599,058.01)	(41,304,263.43)
51210	Өмнөх үеийн үр дүн	(15,599,058.01)	(18,012,578.01)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(23,291,685.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	397,829,650.19	397,829,650.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	840,245,023.18	814,539,817.76

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	480,171,632.00	819,447,027.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,538,800.00	51,857,429.60
120	Нийтлэг татварын бус орлого	51,538,800.00	51,857,429.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,681,800.00	227,420.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,050.00	227,420.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	11,304,900.00	-

120009	Бусад орлого	2,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	37,000,000.00	41,316,209.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	857,000.00	10,313,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,632,832.00	767,589,597.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,530,635.00	99,496,773.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,721,751.00	1,263,798.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,808,884.00	98232975.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	389,102,197.00	668,092,824.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	389,102,197.00	560,634,924.69
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутгийн төсөв/	-	107,457,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	523,770,437.62	771,879,780.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,770,437.62	771,879,780.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,421,117.62	753,286,083.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,885,920.00	265,637,986.00
210101	Үндсэн цалин	167,938,654.00	197,933,286.00
210102	Нэмэгдэл	56,857,221.00	48,416,372.00
210104	Урамшуулал	-	9,233,833.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,090,045.00	10,054,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,104,979.00	33,721,364.82
210201	Тэтгэврийн даатгал	23,330,898.00	22,923,236.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,043.00	2,705,029.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,093.00	2,164,022.69
210204	Ажилгүйдлийн даатгал	502,049.00	519,014.53
210205	Эрүүл мэндийн даатгал	4,753,896.00	5,410,062.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,662,300.00	63,101,749.00
210301	Гэрэл, цахилгаан	6,562,300.00	5,557,569.00

210302	Түлш, халаалт	18,100,000.00	57,544,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,106,978.00	28,807,422.00
210401	Бичиг хэрэг	2,682,108.00	2,531,248.00
210402	Тээвэр, шатахуун	11,708,920.00	13,011,441.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,677,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	612,950.00	4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	297,400.00	379,950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,000,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,207,483.00
2105	Нормативт зардал	600,000.00	198,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	198,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,561,600.00	141,192,218.00
210604	Урсгал засвар	11,561,600.00	141,192,218.00
2107	Томилолт, зочны зардал	2,717,300.00	5,570,000.00
210702	Дотоод албан томилолт	2,717,300.00	5,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,517,855.00	99,278,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,411,955.00	98,172,420.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	199,022.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	288,778.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,264,185.62	115,779,024.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,473,770.00	45,890,894.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	576,550.00	998,320.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,213,865.62	68,889,810.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,349,320.00	18,593,696.87

2132	Бусад урсгал шилжүүлэг	925,000.00	17,671,292.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,926,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	6,280,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	925,000.00	6,464,392.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,424,320.00	922,404.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,424,320.00	922,404.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(43,598,805.62)	49,980,766.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,052,655.47	73,272,451.98
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	150,755,655.47	73,157,451.98
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	297,000.00	115,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(151,052,655.47)	(73,272,451.98)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(194,651,461.09)	(25,705,205.42)

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	438,372,512.00	770,230,537.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,153,200.00	227,420.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,153,200.00	227,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,681,800.00	227,420.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,050.00	227,420.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	11,304,900.00	-
120009	Бусад орлого	471,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,219,312.00	770,003,117.69

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,117,115.00	101,910,293.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,308,231.00	1,263,798.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,808,884.00	100,646,495.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	389,102,197.00	668,092,824.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	389,102,197.00	560,634,924.69
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутгийн төсөв/	-	107,457,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	425,908,372.00	711,730,537.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,908,372.00	711,730,537.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,484,052.00	694,111,840.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,885,920.00	265,637,986.00
210101	Үндсэн цалин	167,938,654.00	197,933,286.00
210102	Нэмэгдэл	56,857,221.00	48,416,372.00
210104	Урамшуулал	-	9,233,833.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,090,045.00	10,054,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,104,979.00	33,721,364.82
210201	Тэтгэврийн даатгал	23,330,898.00	22,904,794.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,043.00	2,704,317.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,093.00	2,162,973.04
210204	Ажилгүйдлийн даатгал	502,049.00	540,543.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,753,896.00	5,408,737.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,662,300.00	66,651,749.00
210301	Гэрэл, цахилгаан	6,562,300.00	5,557,569.00
210302	Түлш, халаалт	18,100,000.00	61,094,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,967,348.00	23,839,989.00
210401	Бичиг хэрэг	2,352,648.00	2,651,248.00
210402	Тээвэр, шатахуун	10,809,100.00	13,011,441.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,677,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	2,000,000.00	4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	2,300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	2,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,152,700.00	137,731,218.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	-
210604	Урсгал засвар	11,552,700.00	137,731,218.00
2107	Томилолт, зочны зардал	2,717,300.00	5,570,000.00
210702	Дотоод албан томилолт	2,717,300.00	5,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,909,495.00	104,216,193.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,703,595.00	103,110,293.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,484,010.00	54,443,341.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,834,010.00	53,345,021.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	1,098,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,424,320.00	17,618,696.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,696,292.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,926,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	6,280,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,489,392.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,424,320.00	922,404.87

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,424,320.00	922,404.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,464,140.00	58,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,249,990.00	58,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,249,990.00	58,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,249,990.00	58,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,149,990.00	58,500,000.00
223001	Бусад хөрөнгө	2,100,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,249,990.00)	(58,500,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,214,150.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15,599,058.01)		840,245,023.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15599058.01)	-	840,245,023.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн	-	-	-		-

	зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15,599,058.01)		840,245,023.18
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15,599,058.01)		840,245,023.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15,599,058.01)		840,245,023.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,705,205.42)		(25,705,205.42)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(41,304,263.43)	-	814,539,817.76

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	689968000.00	667397839.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666968000.00	644397839.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650261100.00	627701547.82

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285904700.00	265637986.00
210101	Үндсэн цалин	210943000.00	197933286.00
210102	Нэмэгдэл	48644800.00	48416372.00
210104	Урамшуулал	7987300.00	9233833.00
210105	Гэрээт ажлын хөлс	18329600.00	10054495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35738100.00	33721364.82
210201	Тэтгэврийн даатгал	24301800.00	22904794.08
210202	Тэтгэмжийн даатгал	2859100.00	2704317.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2287300.00	2162973.04
210204	Ажилгүйдлийн даатгал	571800.00	540543.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5718100.00	5408737.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66790700.00	66651749.00
210301	Гэрэл, цахилгаан	5696300.00	5557569.00
210302	Түлш, халаалт	61094400.00	61094180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23969500.00	23839989.00
210401	Бичиг хэрэг	2651400.00	2651248.00
210402	Тээвэр, шатахуун	13012500.00	13011441.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,677,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	2,300,000.00	2,300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,300,000.00	2,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	173,232,200.00	173,231,218.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,500,000.00	35,500,000.00
210604	Урсгал засвар	137,732,200.00	137,731,218.00
2107	Томилолт, зочны зардал	5,570,000.00	5,570,000.00
210702	Дотоод албан томилолт	5,570,000.00	5,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,305,900.00	2,305,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	418,800.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,450,000.00	54,443,341.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,350,000.00	53,345,021.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,000.00	1,098,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,706,900.00	16,696,292.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,706,900.00	16,696,292.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,926,000.00	4,926,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,280,900.00	6,280,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	5,489,392.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,000,000.00	23,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,000,000.00	23,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	23,000,000.00	23,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	689,968,000.00	668,320,244.69
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	689,668,000.00	668,092,824.69
132001	Орон нутгийн төсвөөс	582,210,100.00	560,634,924.69
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	107,457,900.00	107,457,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	227,420.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	227,420.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	7.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	3.00
650010	Гэрээт ажилтан	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,703,595.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,703,595.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,703,595.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,703,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,703,595.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,117,115.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,117,115.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,308,231.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,808,884.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2022 онд “Иргэдээ дээдэлсэн ухаалаг үйлчилгээг нэвтрүүлсэн төрийн байгууллага байна” гэсэн зорилго тавьжээ. Зорилгын хүрээнд:

-Эмх цэгц дэг журам сахих ба сахиулах жил

-Аймаг сумын ЗД-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн үндсэн 2 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тухайн жилд сумын 4-р багийн “Атар” цогцолборын барилгыг хандив тусламж, нөөц боломжоо ашиглан барьж дуусган ашиглалтад оруулжээ.

Мөн сумын ЗДТГ-ын “Үйлчилгээний нэгдсэн төв”, иргэний танхим, бусад албан хаагчдын өрөө тасалгааны засвар үйлчилгээг хийж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлжээ.

Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг ханган “Боловсон хүчний чадавхжуулах” хөтөлбөрийн хүрээнд 15.0 сая төгрөгийг ОНХС-ийн хөрөнгөөр 7 төрийн албан хаагчдад сургалтын төлбөр болон орон байрны төлбөрт дэмжлэг туслалцаа үзүүлсэн, мөн ажиллах нөхцөл боломжийг сайжруулж компьютер техник хэрэгслээр ханган ажиллаж E-Mongolia-цахим лавлагаатай болж иргэд өөрсдөө чирэгдэлгүй төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Тухайн жил 2 зорилтын хүрээнд 217 ажил төлөвлөснөөс 209 арга хэмжээ нь бүрэн биелэгдэж, 8 ажил дутуу хэрэгжиж 96.2 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай хийсэн эсэхийг шалгахад горим хэрэгжүүлсэн.

Горим сорилоор тус байгууллага нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/27 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тооллогын комисс томилж ажиллуулсан байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-ыг шинэчлэн батлаагүй 2020 онд баталсан бодлогыг баримтлан ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын ЗДТГазар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн баталсан. /2013 онд баталсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.3 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	58453.0	77392.4	18939.4
Үндсэн хөрөнгө	779378.5	737147.4	-42231.1
Нийт хөрөнгө	837831.5	814539.8	-23291.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	458014.4	458014.4	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	837831.5	814539.8	-23291.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 18939.4, үндсэн хөрөнгө 42231.1 мянган төгрөгөөр буурч, нийт хөрөнгийн хэмжээ 23291.7 мянган төгрөгөөр буурчээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 494.8, үйл ажиллагааны орлогоос 0.3, сая төгрөгөөр нийт зарлагыг 495.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан ч 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09/03 тоот тогтоолоор тодотгол хийж зардлыг 689.9 сая төгрөгөөр буюу 194.8 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Энэ нь байгууллагын барилга болон авто машины засвар үйлчилгээ, техник хэрэгсэл худалдан авах шаардлага үүссэнтэй холбогдуулж урсгал засвар, багаж тоног төхөөрөмжийн зардлыг нэмэгдүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 560.6, өмнөх оны үлдэгдлээс 107.5, нэмэлт дансаар аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 91.5, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 4.6, “Булган мээж” ОНӨХХК-иас 5.8, ШШГГ-аас 0.02, сая төгрөгийн нийт 770.2 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 769.3 сая төгрөгийг зарцуулж 0.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 769.3 сая төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	490213.9	569708.1	-79494.2	116
2	Баг хорооны үйл ажиллагааны зардал	67495.1	67414.7	80.4	99.8
3	Нийтлэг үйлчилгээ	37552.1	37552.0	0	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11780.9	11770.3	10.3	99.9
5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	4926.0	4926.0	0	100
6	Бусад	23000.0	23000.0	0	100
7	Орон нутгийн нөөц хөрөнгө	41000.0	40995.0	5.0	99.9
8	Хур хог хаягдал орчны бохирдол	4000.0	4000.0	0	100
9	Улсын их баяр наадам	10000.0	10000.0	0	100

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлтээр дансаар аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 91.5, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 4.6, “Булган мээж” ОНӨХХК-иас 5.8, ШШГГ-аас 0.02 сая төгрөг буюу нийт 101.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр сумын гүүр далангийн ажил хийгдэх зураг төсвийн үнэ, засварын ажилд 86.5, морин эргүүлийн зардалд 5.0, мал тооллого, усны зардалд тус тус холбогдох зардлыг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 668320.2 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 7518.6 төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь нийт 22.6 сая төгрөгийг хэмнэсэн байна. Үүнд: цалингийн зардлыг 20.3, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 2.0, шуудан холбооны зардал 0.02 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан нь нийгмийн ажилтан, бэлчээр газар тариалангийн мэргэжилтний орон тоонд 2022 оны 03 дугаар сараас 11 дүгээр

сар хүртэл ажилтан ажиллаагүй, зарим саруудад мэргэжлийн албан тушаалтан түр орлон /хавсран/ гүйцэтгэсэн, зарим ажилчдад хариуцлага тооцож ажилласан зэргээс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 149 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 145 мэдээг бүрэн мэдээлж 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Томилолтын зардлыг олгохдоо буудлын баримтгүй, албан бус ажлаар явсан ажилтанд 712.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Шатахуун зарцуулалтын 313.5 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны замын хуудасгүй, бараа материалын тайланд орлого дутуу, шууд зардлаар бүртгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Томилолтын зардал тооцон олгохдоо удирдамжгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу 2120.0 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Томилолтын 2120.0 мянган төгрөгийн зардал тооцон олгохдоо удирдамжгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрдүүлж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Малын өсөлт, бууралтын хөдөлгөөнийг жилийн эцэст тайлагнаж, нэг тушаалаар малын хорогдлыг зарцуулснаар тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Шилэн дансанд мэдээлэх мэдээллүүдээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан төсөв гэсэн 4 мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроосон зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;”, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;” 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 9-д “хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2022 оны 05 дүгээр сарын 30-ны өдрийн 3/188 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1454.6	3	1454.6	100
Албан шаардлага	7	272409.8	7	272409.8	100
Зөвлөмж	0	0	0	0	0
Нийт дүн	10	273864.4	10	273864.4	100

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малын өсөлт бууралтын хөдөлгөөнийг цаг тухайд нь тооцон тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

Аудитаар нийт 4.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

5.1 Төлбөрийн акт

Томилолтын зардлыг буудлын баримтгүй, албан бус ажлаар явсан ажилтанд 0.7 сая төгрөгийг олгосон, шатахууны 0.3 сая төгрөгийн зардлыг орлого аваагүй, шууд зардалд тайлагнасан зөрчлүүдэд 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Малын 0.1 сая төгрөгийн өсөлт, бууралтын хөдөлгөөнийг цаг тухайд нь тооцож тайлагнадаггүй, жилийн эцэст нэг тушаалаар хорогдлыг гаргасан байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж, малын өсөлт, бууралтын хөдөлгөөнийг тухай бүр тооцож, бүрэн тайлагнаж ажиллах.

Байгууллагын хөрөнгийн тооллогыг хийхдээ чанартай хийж дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

2. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Томилолтын 2.1 сая төгрөгийн зардал тооцож олгохдоо удирдамжгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрдүүлсэн.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шилэн дансанд мэдээлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан төсөв гэсэн 4 мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлаас буудлын баримт дутуу, албан бус ажлаар явсан ажилтанд олгосон.	1	712.0	1	712.0								
Шатахууны зардлыг шууд зардлаар тайлагнасан.	1	313.5	1	313.5								
Малын өсөлт бууралтын хөдөлгөөнийг цаг тухайд нь тооцоогүй.	1	950.0					1	950.0				
Анхан шатны баримтын бүрдэл	1	2120.0					1	2120.0				

дутуу бүрдүүлсэн.												
Дүн	4	4095.5	2	1025.5			1	3070.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээг хугацаанд нь мэдээлээгүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0					1	0